Улаанбаатар хотын өсвөр насны хүүхдүүдийн замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх мэдлэгийн түвшинг үнэлэх нь

Б.Дагийжав[1], Л.Хоролсүрэн[1], О.Баасандулам[1], Д.Оюунбилэг[1]

[1]АШУҮИС-ийн Нийгмийн Эрүүл Мэндийн Сургууль
Цахим хаяг: Dagiijaw0612@gmail.com, Утас: 99310178

Түлхүүр үг:

Өсвөр үе
Замын тэмдэг
Тэмдэглэгээ
Ерөнхий боловсролын сургууль

Товч утга:

Үндэслэл: Олон улсын түвшинд зам тээврийн осол нь 5-29 насны хүүхэд, залуучуудын нас баралтын тэргүүлэх шалтгааны нэг болж байгаа бөгөөд 2030 он гэхэд нийт хүн амын нас баралтын тэргүүлэх 5 шалтгааны нэг нь зам тээврийн осол болох төлөвтэй байна. Монгол улсын хэмжээнд 2019 онд 819 хүүхэд зам тээврийн осолд өртөж 49 нь амь насаа алдаж 770 нь гэмтэж эрүүл мэндээрээ хохирсон байна. **Зорилго:** Өсвөр насны хүүхдүүдийн замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх мэдлэгийг тодорхойлох. **Материал ба арга зүй:** Судалгааг аналитик судалгааны агшингийн загвараар хийж гүйцэтгэв. Судалгаанд Улаанбаатар хотын Хан-Уул, Сонгинохайрхан, Сүхбаатар, Баянзүрх, Чингэлтэй зэрэг 5 дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн 5-12 ангийн 1061 сурагчдыг санамсаргүй түүвэрлэлтийн аргаар хамруулж, 39 асуулт бүхий асуумжаар мэдээллийг цуглуулан, статистик боловсруулалтыг SPSS 22 программыг ашиглан хийв. **Үр дүн:** Судалгаанд нийт 1061 сурагчид хамрагдсан бөгөөд сурагчдын 60%(637) нь эмэгтэй, 40%(424) нь эрэгтэй байв. Оролцогчдын 73.3%(778) нь дунд бүлгийн буюу 5-9 ангид сурч байв. Судалгаанд оролцсон сурагчдын эцэг, эхчүүдийн дийлэнх нь бүрэн дунд болон дээд боловсролтой хүмүүс байв. Судалгаанд оролцогчид замын тэмдгийн талаар хангалттай мэдлэгтэй байсан бөгөөд улаан, ногоон гэрлэн дохионы илэрхийллийг 99.3%, явган хүний гарцыг анхааруулсан тэмдэглэгээг 56%, явган хүн явахыг хориглосон тэмдэглэгээг 96.5%, сургууль орчмын бүсийг мэдээлсэн тэмдэглэгээг 95.5%, унадаг дугуйг мэдээлсэн тэмдэглэгээг 93.3 хувь нь мэдэж байв. 97.3% нь автомашинаар зорчихдоо суудлын бүс хэрэглэхийг мэддэг, унадаг дугуй унахдаа хамгаалах хэрэгсэл хэрэглэх шаардлагатайг 90.3%(958) нь мэддэг байсан бөгөөд сурагчдын хамгаалах хэрэгсэл хэрэглэх мэдлэгийг хүйсээр нь харьцуулахад охидыг бодвол хөвгүүдэд харьцангуй муу байсан. **Дүгнэлт:** Улаанбаатар хотын өсвөр насны хүүхдүүдийн замын тэмдэг, тэмдэглэгээ, автомашинаар болон дугуйгаар зорчихдоо хамгаалах хэрэгсэл хэрэглэх талаар мэдлэгийн түвшин өндөр хэдий ч хамгаалах хэрэгслийн мэдлэгийг хүйсээр нь харьцуулахад охидыг бодвол хөвгүүдийн мэдлэг дутмаг байна.

Үндэслэл: Олон улсын түвшинд зам тээврийн осол нь 5-29 насны хүүхэд, залуучуудын нас баралтын тэргүүлэх шалтгааны нэг болж байгаа бөгөөд 2030 он гэхэд нийт хүн амын нас баралтын тэргүүлэх 5 шалтгааны нэг нь зам тээврийн осол болох төлөвтэй байна.[1,3]

Хүүхдийн зам тээврийн осол гэмтэл нь дэлхий даяар тулгамдсан асуудлын нэг болоод байна. Хүүхдүүд зам тээврийн осолд өртөх нь тэдний бие бялдар, танин мэдэхүйн чадвар бүрэн хөгжөөгүй байдагтай холбоотой юм.[1]

Монгол улсын хэмжээнд 2019 онд 819 хүүхэд зам тээврийн осолд өртөж 49 нь амь насаа алдаж үүний 770 нь гэмтэж эрүүл мэндээрээ хохирсон байна.[5]

Улсын хэмжээнд 2013-2017онд зам тээврийн осолд өртсөн хүүхдийн тоог насны бүлгээр нь авч үзвэл 0-6 нас 2220 буюу 39.6 хувь, 7-14 нас 2501 буюу 44.6 хувь, 15-17нас 886 буюу 15.8 хувь хүүхэд эзэлж байна. Эрэгтэй хүүхдүүд зам тээврийн осолд өртөж буй хувь эмэгтэй хүүхдүүдийнхээс илүү байна.[3]

7-14 насны хүүхэд өндөр хувийг эзэлж байгаа нь замын хөдөлгөөнд бие даан оролцдог, эцэг эхийн хяналт тодорхой хэмжээгээр буурдаг бие даах чадвар нэмэгддэг хэдий ч тухайн насны хүүхдүүд ид хөдөлгөөнтэй, анхаарал сарнимтгай байдаг гэх мэт насны онцлогтой холбоотой учраас бүх шатны боловсрол сургуулийн байгууллагын сургалтын хөтөлбөрт замын хөдөлгөөнд оролцогчдын мэдлэг, хандлага, дадлыг дээшлүүлэх сургалтыг тусгах хэрэгцээ шаардлагатай байгаа зэрэг нь уг судалгааг хийх үндэслэл болно.

Зорилго: Өсвөр насны хүүхдүүдийн замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх мэдлэгийг тодорхойлох

Зорилт: 10-17насны өсвөр насны хүүхдүүдийн замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх мэдлэгийг үнэлэх

Материал ба арга зүй: Судалгааг аналитик судалгааны агшингийн загвараар хийж гүйцэтгэв. Судалгаанд Улаанбаатар хотын Хан-Уул, Сонгинохайрхан, Сүхбаатар, Баянзүрх, Чингэлтэй зэрэг 5 дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн 5-12 ангийн 1061 сурагчдыг санамсаргүй түүвэрлэлтийн аргаар хамруулж, 39 асуулт бүхий асуумжаар мэдээллийг цуглуулан, статистик боловсруулалтыг SPSS 22 программыг ашиглан хийв.

Үр дүн: Судалгаанд 10-17насны нийт 1061 сурагчид хамрагдсан бөгөөд сурагчдын 60% (637) нь эмэгтэй, 40% (424) нь эрэгтэй байв. Оролцогчдын 778 (73.3%) нь дунд бүлгийн буюу 5-9 ангид сурч байсан. Судалгаанд оролцсон сурагчдын эцэг, эхчүүдийн дийлэнх нь бүрэн дунд болон дээд боловсролтой хүмүүс байв.

Судалгаанд оролцогчдын замын тэмдгийн талаарх мэдлэгийн түвшинг Хүснэгт 1-т харуулласа. Судалгаанд оролцогчид замын тэмдгийн талаар хангалттай мэдлэгтэй байсан бөгөөд улаан, ногоон гэрлэн дохионы илэрхийллийг 99.3% ба 99.2%, явган хүний гарцыг анхааруулсан тэмдэглэгээг 56%, явган хүн явахыг хориглосон тэмдэглэгээг 96.5%, сургууль орчмын бүсийг мэдээлсэн тэмдэглэгээг 95.5%, унадаг дугуйг мэдээлсэн тэмдэглэгээг 93.3 хувь нь мэдэж байв.

Хүснэгт 1. Замын тэмдэг тэмдэглэгээний талаарх мэдлэг (хувиар)

Замын тэмдэг, тэмдэглэгээ	Мэднэ		Мэдэхгүй	
	N	%	N	%
Улаан гэрлэн дохио	1054	99.3	7	0.7
Ногоон гэрлэн дохио	1053	99.2	8	0.8
Явган хүний гарцыг анхааруулсан	596	56.2	465	43.8
Явган хүн явахыг хориглосон	1024	96.5	37	3.5
Сургууль орчмын бүс	1013	95.5	48	4.5
Унадаг дугуйг мэдээлсэн	992	93.5	4	0.4

Судалгаанд оролцогчдын суудлын хамгаалах бүс, унадаг дугуйн хамгаалах хэрэгслийн мэдлэгийг Хүснэгт 2-т харуулласа. Судалгаанд оролцогчдын 97.3%(1032) нь автомашинаар зорчихдоо суудлын бүс хэрэглэхийг мэддэг байсан бөгөөд хүйсээр нь авч үзвэл 59.09%(627) эмэгтэй, 38.1%(405) эрэгтэй хүүхэд нь мэддэг байсан. Харин унадаг дугуй унахдаа хамгаалах хэрэгсэл хэрэглэхийг 90.3%(958) нь мэддэг байсан бөгөөд 55.4%(588) эмэгтэй, эрэгтэй 34.8%(370) хүүхэд нь мэддэг байжээ. Сурагчдын хамгаалах хэрэгсэл хэрэглэх мэдлэгийг хүйсээр нь харьцуулахад охидыг бодвол хөвгүүдийн мэдлэг харьцангуй муу байсан.

Хүснэгт 2. Хамгаалах бүс болон унадаг дугуйн хамгаалах хэрэгслийн мэдлэг (хүйсээр)

Үзүүлэлт	Эрэгтэй				Эмэгтэй			
	Мэднэ		Мэдэхгүй		Мэднэ		Мэдэхгүй	
	N	%	N	%	N	%	N	%
Суудлын бүс	405	38.1	19	1.7	627	59.1	10	0.9
Дугуйн хамгаалах хэрэгсэл	370	34.8	54	5.2	588	55.4	49	4.6

Хэлцэмж: Өсвөр насны хүүхдүүдийн дунд замын хөдөлгөөний мэдлэгийг дээшлүүлэх нь замын хөдөлгөөний дүрмийн аюулгүй байдлын хамгийн чухал асуудал юм.

Бидний судалгаанд оролцогчдын замын тэмдгийн талаар хангалттай мэдлэгтэй байсан бөгөөд улаан, ногоон гэрлэн дохионы илэрхийллийг 99.3% ба 99.2%, явган хүний гарцыг анхааруулсан тэмдэглэгээг 56%, явган хүн явахыг хориглосон тэмдэглэгээг 96.5%, сургууль орчмын бүсийг мэдээлсэн тэмдэглэгээг 95 хувь нь мэдэж байсан. Үүнтэй төстэй мэдлэгийн судалгааг Dr. Humayun Mirza нарын (2013) Лахор хотын сургуулийн хүүхдүүдийн замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаархи мэдлэг, хандлагыг үнэлсэн судалгаанд оролцогчдын замын тэмдгийн талаарх мэдлэгийн түвшин нэлээд өндөр байсан бөгөөд ялангуяа гэрлэн дохионууд 94%, явган хүний гарцыг хориглосон тэмдэг 95%, явган зорчигчийг хориглосон 75% гэсэн тэмдэглэгээг мэдэж байсан9 бол бидний судалгаатай ойролцоо байна.

Судлаач A.Evangeline Mary нарын (2016) Ченнай хотын дунд сургуулийн сурагчдын замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрэм, журмын талаарх мэдлэг, хандлага, дадлыг үнэлэх судалгаанд оролцогчдын 98.1% ба 99.4% нь хөдөлж буй автомашинд суудлын бүсээ заавал өмсөж, хоёр дугуйтай явж байхдаа заавал малгай өмсөх шаардлагатайг мэддэг байв.[10] Харин бидний судалгаанд оролцогчдын 97.3%(1032) нь автомашинаар зорчихдоо суудлын бүс хэрэглэхийг мэддэг, унадаг дугуй унахдаа хамгаалах хэрэгсэл хэрэглэх шаардлагатайг 90.3%(958) нь мэддэг байсан бөгөөд бидний судалгааны үр дүн Ченнай хотын судалгааны үр дүнтэй ижил байв.

Prakash Singh нарын (2020) Дэли хотын эрэгтэй өсвөр насныхны дунд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах мэдлэг, дадлагын түвшинг үнэлсэн судалгаанд дугуй унахдаа хамгаалалтын малгай өмсөх, автомашинаар зорчихдоо хамгаалах бүс заавал хэрэглэх ёстой гэдгийг оролцогчид бүгд мэдэж байсан бөгөөд судалгаанд оролцогчдын 82.0% нь явган хүний гарц замын тэмдгийг мэдэж байсан.[11]

Бидний судалгаанд оролцогчдийн 97.3%(1032) нь автомашинаар зорчихдоо суудлын бүс хэрэглэхийг, унадаг дугуй унахдаа хамгаалах хэрэгсэл хэрэглэхийг 90.3% нь мэдэж байсан нь Дэли хотын судалгааны үр дүнтэй ойролцоо байна.

Дүгнэлт: Улаанбаатар хотын өсвөр насны хүүхдүүдийн замын тэмдэг, тэмдэглэгээ, автомашинаар болон дугуйгаар зорчихдоо хамгаалах хэрэгсэл хэрэглэх талаар мэдлэгийн түвшин өндөр хэдий ч хамгаалах хэрэгслийн мэдлэгийг хүйсээр нь харьцуулахад охидыг бодвол хөвгүүдийн мэдлэг дутмаг байна.

Талархал: Судалгаа явуулахад хамтран ажилласан ЦЕГ Тээврийн Цагдаагийн Албаны урьдчилан сэргийлэх хэлтсийн ахлах мэргэжилтнүүд, Баянзүрх дүүргийн 102 дугаар сургууль, Сүхбаатар дүүргийн Эрдмийн хөтөч цогцолбор сургууль, Чингэлтэй дүүргийн 50 дугаар сургууль, Сонгинохайрхан дүүргийн 9 дүгээр сургууль, Хан Уул дүүргийн 34 дүгээр сургуулиудын захирал, нийгмийн ажилтан, багш нар болон судалгаанд оролцохыг зөвшөөрсөн эцэг эх, сурагч нарт талархлаа илэрхийлж, цаашдын ажилд нь амжилт хүсье.

Ном зүй:

1. *World Health Organization. Ten strategies for keeping children safe on the road. 2015.x.1-20. http://www.who.into// 2021.03.10*
2. *Word Health Organization: Report on road traffic injury prevention. Geneva 2004.x.30-65. http://www.who.into// 2020.04.15*
3. *Судалгаа зөвлөх үйлчилгээний Эм Эм Си Жи ХХК, Хууль сахиулахын их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэмтэд хамтын бүтээл.Замын хөдөлгөөн дэх хүүхдийн аюулгүй байдал, осол гэмтлийн нөхцөл байдал үнэлгээний тайлан. Улаанбаатар; 2019.x.4-14*
4. *Цагдаагийн ерөнхий газар, Замын цагдаагийн алба."Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл. Улаанбаатар; 2020.x.46-54.*
5. *Цагдаагийн ерөнхий газрын Замын Цагдаагийн алба. Зам тээврийн осол, гэмт хэргийн нөхцөл байдал тойм мэдээлэл. Улаанбаатар; 2019. http://transportation.police.gov.mn.2020.05.01*
6. *Монгол Улсын Засгийн газрын тогтоол. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль. https://Legalinfo.mn/annex/details/ 2021.04.01*
7. *Монгол Улсын Стандарт."Сургуулийн бүс" Техникийн ерөнхий шаардлага. MNS6444:2014. Улаанбаатар: Үндэсний стандарт хэмжилзүйн газар; http://estandart.gov.mn. 2021.04.01*
8. *Mihaela Rus, Tănase Tasenţe, Ciprian Vasile Rus. Preventive Behaviors and Attitudes of the Children as Active Participants in Road Traffic. ACTA UNIVERSITATIS DANUBIUS. 1/2019; Vol.11,105-112*
9. *Humayun Mirza Dr, Seema Daud Head Prof. Study of knowledge, attitude and practice regarding road safety among peri-urban school children. 2013-researchgate.net.2-13*
10. *Evangeline mary dr. A, chitra dr. A, arunmozhi dr. R, sheila doris dr. T.A cross sectional study to assess the knowledge, attitude and practice towards Road safety rules and regulations among higher secondary school students in Chennai. Indian journal of basic and applied medical research; issue- 4: september 2016; Vol.-5, 779-789*
11. *Prakash Singh, and Pushpanjali Swain. Assessment of the level of knowledge and practice towards road traffic safety among male adolescents in urban slums of delhi. International Journal of Research-Granthaalayah.May 2020; Vol 8(05),165-17*
12. *Adebimpe, Wasiu O., Dabo, Daniel, Osifo, Joy A., Ibirongbe, Demilade, Gbahabo, Dooshima, and Adesina, Afusat. Knowledge of Road Signs and Attitude to Safety Measures Among Public Secondary School Students in Jos Nigeria. In: Journal of Health and Medical Sciences, 2019; Vol.2, No.4, 524-531.*

Evaluation of knowledge level regarding traffic safety among adolescents in Ulaanbaatar

Dagiijav B[1], Khorolsuren L[1], Baasandulam O[1], Oyunbileg D[1]

[1]School of Public Health, MNUMS
Email: Dagiijaw0612@gmail.com, Tel: 99310178

Introduction: At the international level, traffic accidents are one of the leading causes of death among children and youth aged 5-29, and by 2030, traffic accidents are expected to be one of the top five causes of death in the general population. In Mongolia, 2019, total of 819 children were involved in traffic accident, 49 of them died and 770 of them were injured.
Objectives: We aimed to evaluate knowledge and attitude of adolescents regarding traffic safety.
Material and methods: Total of 1061 students who were 5-12th grade from General education schools of Khan-Uul, Songinokhairkhan, Sukhbaatar, Bayanzurkh and Chingeltey district at Ulaanbaatar were included by randomized method in the study. Moreover, questionnaire consists of 39 items were used to collect data and statistical analysis was made by SPSS 22 software.
Results: Female students were equal to 60%(637) of total 1061 students. Furthermore, 73.3%(778) of them were studying at 5-9th grade. Major part of participants' parents earned high school and higher education. Participants were highly aware of traffic signs and 99.3%; 56%; 96.5% and 93.3% were aware of traffic lights such as red and green, pedestrian sign, no pedestrian sign, school zone sign and bicycle traffic sign, respectively. Moreover, 97.3% of participants were aware of fastening seat belts while on the road and 958(90.3%) of them were aware of wearing protective gear while riding bicycle.
Conclusion: Although information level regarding traffic signs and importance of wearing protective gear and fastening seat belts was higher among adolescents, in comparison with females, the level of the knowledge was lower among males.

Keywords: adolescents, traffic signs, symbols, general education school